

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“Баруун-урт сумын 1-р баг 3-р сургуулийн урд талаас баруун тийш 4-р сургууль, 2-р цэцэрлэгийн дундах уулзвар хүртлэх 420 м хатуу хучилттай авто зам дагуух явган замын өргөтгөл, шинэчлэлийн ажил”

Ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд:

1. Гүйцэтгэгч гэрээний баримт бичгүүдийг холбогдох байгууллагуудад танилцуулж явган замын ажил эхлүүлэх зөвшөөрлийг авсан байна.
2. Явган замын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэхдээ бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээ болон оршин суугчдын ая тухтай, аюулгүй зорчиход ямар нэгэн саад бэрхшээл учруулахгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах шаардлагатай.
3. Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллах.
4. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, холбогдох БНБД стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

Захиалагчийн хяналт:

1. Явган замын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг гүйцэтгэж эхлэхээс дуусах хүртэлх бүх технологийн үйл ажиллагаа.
2. Материалын чанар.
3. Батлагдсан ажлын даалгавар, тоо хэмжээ, норм, дүрэм, технологийн шаардлагыг зөрчсөн нөхцөлд захиалагч байгууллагын эрх бүхий төлөөлөгчид, мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчид барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Гүйцэтгэгч байгууллага:

1. Гүйцэтгэгч байгууллага нь байршлын зураг, батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу тус ажлыг чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Ажлын талбайд журнал хөтөлж, хяналтын инженерүүдийн өгсөн үүрэг даалгавар, шаардлага, дүгнэлтийн биелэлтийг гаргана.
3. Бүх үе шатны ажлуудад тухай бүрт нь хэмжилт хийх фото зургаар баталгаажуулна.
4. Монгол улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дагуу баталгаа гаргаж өгнө.
5. Ажлын явцад өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрсэн байгууламжуудыг нөхөн сэргээн засварлаж хэвийн байдалд оруулна.
6. Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшгаас сэргийлэн даатгалд бүрэн хамрагдан аюулгүй байдлыг хангаж ажиллана.
7. Эдгээр арга хэмжээг авалгүй гэнэтийн гамшигт өртөх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зөрчил гаргавал хор хохирлыг гүйцэтгэгч бүрэн хариуцна.
8. Засварын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд хийж гүйцэтгэсэн ажилдаа баталгаа гаргана.

9. Хэрвээ зураг төсөл, төсөвт өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 14 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд батлагдсан төлөвлөлтийн гүйцэтгэнэ.

Ерөнхий төлөвлөгөө, үзүүлэлт, техникийн шийдэл, цар хүрээ, тавигдах шаардлага:

Гүйцэтгэгч дараах зүйлээс бүрдсэн ажлын төлөвлөгөөг захиалагчаар батлуулахаар танилцуулна.

1. Гүйцэтгэгч ажлын нарийвчилсан график

2. Санхүүжилтийн хуваарь: Хуулийн дагуу урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлсэн тохиолдолд урьдчилгаа төлбөр олгож болно. Санхүүжилтийг үе шатаар гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

3. Гүйцэтгэгч нь Баруун-урт сумын 1-р баг 3-р сургуулийн урд талаас баруун тийш 4-р сургууль, 2-р цэцэрлэгийн дундах уулзвар хүртлэх 420 м хатуу хучилттай авто зам дагуух явган замын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг тендериийн баримт бичиг, байршлын зураг, батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу хийж гүйцэтгэнэ. Тус ажлыг гүйцэтгэхдээ авто зам, барилга байгууламжид тавигдах техникийн шаардлага болон стандарт, технологи дарааллыг мөрдлөгө болгон талбайн инженерийн зааварчилгаа зөвшөөрлийн дагуу хийж гүйцэтгэж ашиглалтанд оруулна.

Одоо байгаа байдал: Тус 420 у/м авто замын зөвхөн хойд хэсэгт явган зам хийгдсэн боловч урд хэсгээр явган зам байхгүй байгаагаас Баруун-Урт хотын иргэд, 3,4-р сургууль, 2-р цэцэрлэгийн хүүхдүүд замын зорчих хэсгээр ажил, сургууль, цэцэрлэг рүү явж, замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үүсдэг.

Төлөвлөлт: Төлөвлөсөн байршлын авто замын дагуух чиглэлд ажлын тоо хэмжээний дагуу хөрс хуулах, элс, хайрган хольцоор суурь байгуулах, явган хүний замын суурийг байгуулах, явган замын хашлага тавих, цутгах, өнгөт хавтан суурилуулах, хийн нягтуулагчаар хөрсийг нягтуулах, 1 байршилд ус зайлцуулах лотки /тэвш-/г төмөр бетоноор цутгах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих хөдөлгөөн зохион байгуулалт, стандарт шаардлага хангасан хавтан, тоноглол хийх.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь: импортын материал худалдан авах тохиолдолд тохиролын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторын шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ”, лабораторийн шинжилгээний дүн, падаан хавсаргана. Мөн орон нутгаас хэрэглэх элс, хайрганы шинжилгээний дүнг барилгын хувийн хэрэгт хавсаргана.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Х ЭНХЦЭЦЭГ